

## **Хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар мэдээлэх, мэдээлэл өгөх журам**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар олон нийтэд мэдээлэх, байгууллага, иргэдэд мэдээлэл өгөхтэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигын эсрэг хуулийн 14.1, 14.2 дахь хэсгийг үндэслэн хэвлэн нийтлэх, цахим мэдээллийн сүлжээнд байрлуулахдаа Хувь хүний нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, 5.4 дэх хэсгүүд, 6 дугаар зүйлд заасныг тус тус баримтална.

### **Хоёр. Хөрөнгө, орлогын мэдүүлгийг олон нийтэд мэдээлэх**

2.1. Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг энэ журмын 2.2-т заасны дагуу дараахь хэлбэрээр мэдээлнэ. Үүнд:

2.1.1. “Төрийн мэдээлэл” сэтгүүлд хэвлэн нийтлэх;

2.1.2. Авлигатай тэмцэх газрын цахим мэдээллийн сүлжээнд байрлуулах.

2.2. Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг олон нийтэд мэдээлэхдээ дараахь байдлаар нийтэлнэ. /энэ журмын 1-р хавсралт/

2.2.1. Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагчийн овог, нэр, албан тушаалын байдал.

2.2.2. Хөрөнгө, орлогын мэдүүлгийн “Орлого” хэсэгт мэдүүлэг гаргагчийн болон хамт амьдарч байгаа гэр бүлийн гишүүдийн тухайн жилд олсон нийт орлогын дүн.

2.2.3. “Хөрөнгө, зээл, бэлэг” хэсэгт “Барилга байгууламж”, “Авто тээврийн хэрэгсэл”, “Мал”, “Газар”, “Эрх, концесс, лиценз” гэсэн үзүүлэлтийн тус бүрийн зориулалт, төрөл, тоо хэмжээ, үнийн дүн.

2.2.4. Мөн хэсгийн “Хадгаламж”-ийн жилийн эцсийн үлдэгдлийн төгрөгөөр илэрхийлсэн дүн.

2.2.5. Мөн хэсгийн “Хөрөнгө оруулалт, хувьцаа” үзүүлэлтээс мэдүүлэг гаргагчийн болон түүний гэр бүлийн гишүүдийн хөрөнгө оруулалт хийж хувь оруулсан хуулийн этгээдийн нэр, эзэмшлийн хувь хэмжээ, хувьцааны тоо ширхэг, хөрөнгө оруулалтын нийт дүн.

2.2.6. Мөн хэсгийн “Зээл”-ийн зээлдүүлэгчийн нэр, зээлийн дүн, “Бэлэг”-ийн эх сурвалжийн нэр, нийт үнийн дүн.

2.3. Авлигын эсрэг хуулийн 14.1-д заасан албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг энэ журмын 2.2-д заасны дагуу тухайн оны 2 дугаар улиралд багтаан олон нийтэд мэдээлнэ.

2.4. Авлигын эсрэг хуулийн 4.1-д заасан этгээдийн хөрөнгө, орлогын сүүлийн 5 жилийн мэдүүлгийг Авлигатай тэмцэх газрын цахим мэдээллийн сүлжээнд байрлуулахдаа энэ журмын 2.2-т заасныг баримтална.

2.5. Авлигатай тэмцэх газар албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах журмын биелэлтийн талаар Авлигын эсрэг хуулийн 10.4-т заасан хугацаанаас хойш 45 хоногийн дотор олон нийтэд мэдээлнэ.

### **Гурав. Хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар байгууллага, иргэдэд мэдээлэл өгөх**

3.1. Байгууллага, иргэд /цаашид “мэдээлэл хүсэгч” гэх/-ийн хүсэлтийн дагуу албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар түүнийг хадгалж буй байгууллагын удирдлагын зөвшөөрлөөр хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтан энэ журмын 2.2-т заасныг баримтлан мэдээлэл өгнө.

3.2. Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар дараахь хэлбэрээр мэдээлэл өгнө.

3.2.1. Энэ журмын “хавсралт-1” маягтын хуулбараар;

3.2.2. Нийтийн болон электрон шуудангаар;

3.2.3. Амаар;

3.2.4. Холбооны хэрэгслээр;

3.2.5. Хууль, тогтоомжоор хориглоогүй бусад хэлбэр.

3.3. Иргэд, байгууллагаас албан тушаалтны хөрөнгө, орлогын талаар мэдээлэл авахаар гаргасан хүсэлтийн дагуу дараахь албан тушаалтан зөвшөөрөл олгоно.

3.3.1 Авлигын эсрэг хуулийн 14.1-д заасан албан тушаалтны хөрөнгө, орлогын талаар Авлигатай тэмцэх газрын дарга;

3.3.2 Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, шүүгчээс бусад бүх шатны шүүхийн шүүгч, шүүхийн тамгын газар, хэлтэс, албаны дарга нарын хөрөнгө, орлогын талаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга;

3.3.3 Засгийн газраас томилогддог албан тушаалтны хөрөнгө, орлогын талаар Төрийн албаны зөвлөлийн дарга;

3.3.4 Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн захирал, тэдгээрийн төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж байгаа болон захиргааны албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчдын хөрөнгө, орлогын талаар Төрийн өмчийн хорооны дарга;

3.3.5 Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн захирлын хөрөнгө, орлогын талаар тухайн орон нутгийн Засаг дарга;

3.3.6 Төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг хууль тогтоомжоор тогтоосон журмын дагуу түр, эсвэл байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах болон гүйцэтгэх ажилтаны хөрөнгө, орлогын талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга;

3.3.7 Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын төрийн жинхэнэ албан хаагчдын хөрөнгө, орлогын талаар харъяалах аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга;

3.3.8 Төрийн захиргааны болон тусгай албан тушаал эрхэлж байгаа төрийн бусад албан хаагчдын хөрөнгө, орлогын талаар түүнийг томилсон болон удирддаг албан тушаалтан;

3.3.9 Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Хурлын төлөөлөгчид, сум дүүргийн хурлын дарга, нарийн бичгийн дарга, сум дүүргийн Засаг дарга, түүний орлогч, баг хорооны Засаг дарга нарын хөрөнгө, орлогын талаар аймаг, нийслэлийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга;

3.3.10 Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын, бүх шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын талаар тухайн шатны Сонгуулийн хорооны дарга;

3.3.11 Төрийн албаны тухай хуулийн 6.1.14, 6.1.15-д заасан улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийнх нь хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх, туслах, хэвлэл мэдээллийн ажилтан, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны ажилтан нарын хөрөнгө, орлогын талаар харъяалагдах төрийн байгууллагын Тамгын газрын дарга тус тус зөвшөөрөл олгоно.

3.4. Мэдээлэл хүсэгчийн хүсэлт нь энэхүү журмын 4.4, 4.5-д заасныг хангаж байгаа бол зөвшөөрлийг олгоно.

3.5. Зөвшөөрөл олгох албан тушаалтан мэдээлэл хүсэгчид зөвшөөрөл олгохдоо Авлигатай тэмцэх газартай зөвшилцөж болно.

3.6. Зөвшөөрлийг зөвхөн бичгээр өгөх ба түүнийг утсан холбоо /факсаар/, баталгаат шуудангаар дамжуулж болно.

3.7. Энэ журмын 3.3-д заасан зөвшөөрөл олгох эрх бүхий албан тушаалтныг эзгүйд түүнийг орлож байгаа албан тушаалтан мэдээлэл өгөх зөвшөөрөл олгоно.

3.8. Энэ журамд зааснаас бусад тохиолдолд хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар мэдээлэл өгөх зөвшөөрөл олгохыг хориглоно.

3.9. Зөвшөөрөл олгох албан тушаалтан мэдээлэл хүсэгчийн хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор энэхүү журмын дагуу хянан шийдвэрлэх бөгөөд мэдээлэл өгөх боломжгүй гэж үзвэл тэр даруй хүсэлт гаргагчид үндэслэлээ тайлбарлана. Хүсэлт гаргагч уг шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол Авлигатай тэмцэх газарт хандаж болно.

3.10. Мэдээлэл хүсэгчид мэдээлэл өгөх зөвшөөрөл олгосноос хойш ажлын 2 хоногийн дотор албан тушаалтны хөрөнгө, орлогын талаарх мэдээллийг өгнө.

**Дөрөв. Мэдээлэл авах хүсэлт гаргах, хүсэлт гаргагчийн эрх, үүрэг**

4.1.Мэдээлэл хүсэгч нь албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар өөрт байгаа мэдээллээ магадлах, шалгах үүднээс энэхүү журмаар зөвшөөрөгдсөн хэмжээнд мэдээлэл авах эрхтэй.

4.2.Албан тушаалтны хөрөнгө, орлогын талаар мэдээлэл авах хүсэлтээ түүний удирдлагад буюу зөвшөөрөл олгох эрх бүхий албан тушаалтанд хандаж бичгээр гаргана.

4.3.Мэдээлэл хүсэгч энэ журмын 3.2-д заасан мэдээлэл авах хэлбэрээс сонгох эрхтэй.

4.4.Мэдээлэл хүсэгч нь энэ журмын 2-р хавсралтын асуултанд үнэн зөв хариулсан байна.

4.5.Хөрөнгө, орлогын талаар мэдээлэл авсантай холбоотой үүссэн хариуцлагыг хүлээх эрхзүйн чадамжтай байна.

4.6.Мэдээлэл авсан этгээд авсан мэдээллээ түгээх, ашиглахдаа Үндсэн хууль, бусад хуулийг зөрчихгүй байх, хувь хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх үүрэгтэй.

4.7.Мэдээлэл авсан этгээд энэхүү журмын 4.6-д заасан үүргийг биелүүлээгүй бол хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

#### **Тав. Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны эрх, үүрэг**

5.1. Мэдээлэл хүсэгчид хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар мэдээлэх, мэдээлэл өгөх журмыг урьдчилан танилцуулна.

5.2. Мэдээлэл хүсэгчийн хүсэлтийг шаардлага хангасан гэж үзвэл зөвшөөрөл олгох эрх бүхий албан тушаалтанд танилцуулна.

5.3. Зөвшөөрөл олгох албан тушаалтан мэдээлэл өгөх зөвшөөрлийг олгосноос хойш энэхүү журмын 3.10-д заасан хугацаанд мэдээлэл хүсэгчид албан тушаалтны хөрөнгө, орлогын талаарх мэдээллийг өгнө.

5.4. Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтан нь мэдээлэл хүсэгчийн хүсэлтийг хүлээн авч өөрийн эрх хэмжээний хүрээнд танилцаж энэхүү журмын 4.2, 4.5-д заасныг хангаагүй бол буцаах эрхтэй.

5.5. Мэдээлэл авсан байгууллага, иргэдийн нэр, хаяг, хүсэлтийн агуулга, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаар бүртгэл /энэ журмын хавсралт-3/ хөтөлж, Авлигатай тэмцэх газарт улирал тутам тайланг ирүүлнэ.

5.6. Эрх бүхий албан тушаалтан мэдээлэл өгөхтэй холбоотойгоор өөрт тодорхой болсон мэдээлэл болон мэдээлэл авсан иргэний нэр, хүсэлт, түүний бүртгэлийн нууцыг хадгална.

#### **Зургаа. Бусад**

6.1. Авлигатай тэмцэх газраас зөвшөөрсөн бол энэ журмын 3.3-д заасан албан тушаалтан мөн журмын 4.2, 4.5-д заасан нөхцлийг шаардахгүйгээр мэдээлэл хүссэн байгууллагад мэдээллийг бичгээр өгнө.

6.2. Мэдүүлэг гаргагч өөрөө хүсэлт гаргасан буюу зөвшөөрсөн бол түүний хөрөнгө, орлогын талаар мэдээллийг өөрт нь болон бусдад өгч болно.

6.3. Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон тухайн албан тушаалаас чөлөөлөгдсөнөөс хойшхи хугацаанд мэдүүлэг гаргагчийн зөвшөөрөл болон энэ журамд зааснаас бусад тохиолдолд хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй холбоотой мэдээллийг задруулах болон албан бус зорилгоор ашиглахыг хориглоно.

----- о О о -----